




БАЙГУУЛЛАГЫН ИЛ ТОД БАЙДЛЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

№	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэл
<i>Нэг. Үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдал</i>		
	<ul style="list-style-type: none"> • Төрийн үйлчилгээ, захидал харилцааны асуудал хариуцсан албан хаагчийн овог, нэр, албан тушаал, хариуцсан ажил, ажиллах журам, харилцах утас, иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарийг нээлттэй, ил тод байрлуулсан эсэх 	<p>Төрийн үйлчилгээ, захидал харилцааны асуудал хариуцсан албан хаагчийн орон тоогоор батлагдсан ажилтан одоогоор байхгүй байна.</p> <p>Иргэдийн санал, хүсэлт, талархал, өргөдөл, гомдол зэргийг байгууллагын захирал, эмчилгээ эрхэлсэн орлогч захирал, чанарын алба, бичиг хэрэг гэсэн 4 цэг дээр хүлээн авдаг. Нээлттэй утас 70433488 утсаар чанарын албаны лавлагаа мэдээлэлийн ажилтан хүлээн авч шийдвэрлүүлэх, мэдээлэлийн самбараар дамжуулан ил тод байдлыг ханган ажиллаж байна.</p>
	<ul style="list-style-type: none"> • Үйлчилгээг боловсронгуй болгох чиглэлээр авсан арга хэмжээний хэрэгжилтийн хувь; 	<p>Үйлчилгээг боловсронгуй болгох чиглэлээр авсан арга хэмжээний хэрэгжилтийн хувь 90%</p> <ol style="list-style-type: none"> 1. Үйлчилгээг цахим бүртгэлжүүлж цахим бүртгэлийн хэсэгт дугаарлагч машин, урсдаг электрон самбар, дотоод цахим сүлжээ, хяналтын камер гэх мэт тоног төхөөрөмж бүхий цогц үйлчилгээг нэвтрүүлсэн. 2. Үзлэгийн бүр кабинетууд, лаборатори, рентген зэргийг хамруулан тодорхой цаг өгөх, цагийн захиалга авах, шинжилгээний хариуг цахимаар цаасан хэлбэрт оруулан гаргаж өгөх зэрэг үйлчилгээг нэвтрүүлсэн. 3. Амбулатори болон бүх тасаг нэгжүүдэд хаяг,дуугүй хөтөч, ажлын цагийн хуваарийг шинэчлэн хийсэн. 4. Үйлчлүүлэгчийн угтах үйлчилгээг сайжруулах зорилгоор 2 хөтөч сувилагчийг ажиллуулж байна. 5. Хүлээн авах яаралтай тусламжийн тасагт их засвар хийж өрөө тасалгааны тоог нэмэгдүүлэн тусгаарлах өрөө, хүлээн авах өрөө, онош тодруулж яаралтай тусламж үзүүлэх өрөө гэх мэт урсгалыг нэг чиглэлтэй болгосон 6. Шинжилгээний тасгийн урсгалыг зөв болгож стандартын дагуу зохион байгуулсан.
	<ul style="list-style-type: none"> • Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой хуулиар хориглоогүй аливаа мэдээллийг иргэдэд 	<ol style="list-style-type: none"> 1. Үзүүлж буй тусламж үйлчилгээний жагсаалт, төлбөрт үйлчилгээний үнийн тарифыг ил тод байрлуулсан. 2. Байгууллага суртачилах самбар

	<p>үнэ төлбөргүй, хүндрэл чирэгдэлгүй өгөх талаар зохион байгуулсан арга хэмжээний хэрэгжилтийн хувь;</p>	<p>3. Тасаг нэгж кабинетуудын байршлыг схем зураглалыг шинээр хийж байршуулсан 4. Дотоод, гадаад цахим үйлчилгээг өргөжүүлэн байгууллагын вэб сайтыг тогтмол ажиллуулж ард иргэдэд мэдээлэл хүргэн ажиллаж байна 5. Байгууллагын тасаг, албадуудын үйл ажиллагааны танилцуулгын самбараар дамжуулан тогтмол ажиллуулж хэвшсэн.</p> <p>Биелэлт 90%</p>
	<ul style="list-style-type: none"> Байгууллагын дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төслийг боловсруулахдаа холбогдох төрийн ба төрийн бус байгууллага, мэргэжлийн шинжээч, эрдэмтэн, иргэдээс хэдэн санал авсан, үндэслэлтэй гэж үзээд төсөлд тусгасан саналын тоо; 	<p>Байгууллагын үйлдвэрчний эвлэлийн хороотой хийсэн хамтын гэрээг 2013 оны 03 сарын 01-ний өдрөө 2 жилийн хугацаатай 10 бүлэг 135 зүйлтэйгээр байгуулан Ховд аймгийн Жаргалант сумын тамгын газрын даргаар баталгаажуулан мөрдөн ажиллаж байна. Хамтын гэрээг шинэчлэн боловсруулахад аймгийн мэргэжлийн хяналтын газар, аймгийн хууль зүйн хэлтэс, нийгмийн даатгал, хөдөлмөрийн хэлтэс, аймгийн үйлдвэрчний эвлэлийн хороо зэрэг байгууллагуудаас мэргэжил арга зүйн зөвлөгөө авч ажилласан.</p>
	<ul style="list-style-type: none"> Санал, хүсэлт, өргөдөл, гомдол, мэдээлэл хүлээн авах утас буюу хайрцаг (дэвтэр) ажиллуулаад түүний мөрөөр авсан арга хэмжээний хэрэгжилтийн хувь; 	<p>Санал хүсэлтийн хайрцаг 3 газар, санал хүсэлтийн дэвтэр улиралд нэг удаа тасаг, нэгжүүдээр аялуулдаг. Өргөдөл гомдлыг бичиг хэрэгийн ажилтан хүлээн авч бүртгэн удирдлагад танилцуулан шийдвэрлүүлсэний даргаа хариу мэдэгддэг. Санал гомдол хүлээн авах нээлтэй утас 70433853 ажиллуулдаг.</p> <ul style="list-style-type: none"> Үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн судалгааг улирал тутамд хийж үзэхэд 57,7%, 2-р улиралд 66,8%, 3-р улиралд 70,1% Ажилчдаас авсан сэтгэл ханамжийн судалгааг хагас жилд нэг удаа авахад эхний хагас жилд 65,9%, 2-р хагаст 72,0% Дэмжлэгт удирдлагын талаар ажилчдаас асуумжийн хуудсаар 2 удаа судалгаа авахад сайн-24,5%, дунд 35,9%, хангалтгүй 39,5% Эвлэрүүлэн зуучилсан- 29 тохиолдол
	<ul style="list-style-type: none"> Хэдэн өргөдөл, гомдлыг хуульд заасан хугацаанд шийдвэрлэж, хариу 	<p>Хуульд заасан хугацаанд шийдвэрлэж хариу өгсөн өргөдөл, гомдлын хувь -100%</p> <p>Өргөдөл гомдол: бичгээр -29, амаар-5, талархал-86 ирсэнийг тухайн үед нь танилцуулж 5 өргөдөл</p>

	өгсөн.	удирдлагын багийн хурлаар шийдвэрлэсэн.
<i>Хоёр. Хүний нөөцийн бодлогын ил тод байдал</i>		
	<ul style="list-style-type: none"> • Байгууллагын соёл, зохион байгуулалт, үйл ажиллагааны нээлттэй байдлын талаархи сэтгэл ханамжийн судалгааг ажилтнуудаас авч, түүний мөрөөр авсан арга хэмжээний тоо; 	 <p>- Байгууллагын соёл, зохион байгуулалт үйл ажиллагааны нээлттэй байдлын талаархи сэтгэл ханамжийн судалгааг ажилтнуудаас авч, түүний мөрөөр авсан арга хэмжээний тоо-2012 онд Байгууллагын соёл, зохион байгуулалт, үйл ажиллагаатай холбоотой санал авах хайрцагийг захиргааны хэсэгт 2013 оны 2 сараас эхлэн ажиллуулж мөн тасаг хамт олноос санал авч нийт 194 хүнээс асуумжаар боло н харилцан ярилцах маягаар судалгаа авсан. Дүгнэлт: БОЭТ-ийн барилгын засварыг чанартай гүйцэтгүүлэх,гэрэлтүүлэг ,дулаан хангамжийг сайжруулах гэм мэт 2012 онтой харьцуулахад байгууллагын соёл, зохион байгуулалт үйл ажиллагаатай холбоотой сэтгэл ханамж 32,1 %-иар дээшилсэн байна. Энэ онд шинээр үйлчлүүлэгчдэд зориулан байгууллагын алдрын буланг нээж ил тод байршуулсан. Амбулаторийн хэсэг болон үйлчлүүлэгчдийн төвлөрсөн нягтрал ихтэй газарт, орон нутгийн байгалийн үзэсгэлэнт газрын зураг, төрийн соёрхолт зохиолч О.Дашбалбарын “Амьддаа бие биеэ хайрла хүмүүсээ”, “Өөдрөг явах 25 зарчим”, Онч мэргэн үгс, дуугүй хөтөч, Сэтгэлд нийсэн эрүүл мэндийн найман үйлчилгээ Амаржих газарт яруу найрагч, сэтгүүлч Б.Энхтуяагийн “Охин үрээ хайрла” шүлэг, төрийн албан хаагчийн эрхэмлэх 9 зүйл, аюулгүй ажиллагааны зааварчилгаа, самбар зэргийг шинэчлэн байршууллаа.</p>   
	<ul style="list-style-type: none"> • Сул орон тооны зарыг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр 	<p>Сул орон тооны зарыг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр нээлттэй зарлаж, сонгон шалгаруулах журмын дагуу шалгаруулсан ажилтны тоо-2 Сул орон</p>

		<p>тайланг гаргах ажлыг хүний нөөцийн менежерт төвлөрүүлнэ.</p> <p>Ажлын байранд бусдыг үл хүндэтгэн тамхи татах, тамхины ишийг хаях зөрчил гаргахгүй байхаар санамж бичиж байршуулсан</p> <p>Байгууллагын стационарын хэсгийн 1,2 давхарын фестиваль болон шатны хэсэгт тамхины эсрэг лого, таних тэмдэг байршуулсан.</p>
	<p>Ажилтнуудыг сургах, орчин үеийн мэдээллээр хангах дэд бүтцийг бүрдүүлэх үйл ажиллагааны гүйцэтгэлийн хувь;</p>	<ul style="list-style-type: none"> - Ажилтнуудыг сургах, орчин үеийн мэдээллээр хангах дэд бүтцийг бүрдүүлэх үйл ажиллагааны гүйцэтгэлийн хувь- 95% • Төлөвлөгөөний дагуу 2013 оны эхний 11 сарын байдлаар 56 удаагийн сургалтыг зохион байгуулж нийт давхардсан тоогоор 2561 хүн хамрагдсан байна. • Баруун бүсийн эмч, эмнэлгийн мэргэжилтний II зөвлөгөөнийг 2013 оны 8 сарын 18-21-ний хооронд зохион байгуулсан. • Гадаад хамтын ажиллагааны сургалтанд удаагийн сургалтанд 9 эмч, сувилагч нар хамрагдсан байна • 17 удаа сургалтын хөтөлбөр боловсруулан батлуулж эмч мэргэжилтнүүдэд дотоодын сургалт, эм ханган нийлүүлэх байгууллагуудын багц цагийн сургалт, хууль эрх зүй, авилгын тухай, эмчийн ёс зүй, телемедицины зайн сургалт, ижил мэргэжилтний үзлэг хийх зэрэг сургалт зохион байгуулж эмч эмнэлгийн мэргэжилтэн идэвхитэй оролцлоо. • Богино хугацааны албан бус сургалтанд / улаанбаатар болон өөр аймаг хотод / 50 гаруй сургалтанд 70 гаруй хүн хамрагдсан. • Кредиттэй сургалтанд 13 удаагийн сургалтанд давхардсан тоогоор 981 мэргэжилтэн хамрагдсан байна. • ЭМШУИС, Гавь-алтай аймаг дахь АУК, Монос, Этүгэн, Ая анагаах ухааны дээд сургууль, Дархан, Сувилахуйн сургуулийн оюутны зуны дадлагыг удирдлага зохион байгуулалтаар ханган ажиллаа. - Солонгос Улсын дэмжлэгээр нярайн их эмч Ц.Доржхандыг 3 сарын хугацаатай сургалтанд хамрууллаа

		<ul style="list-style-type: none"> - Тайлант онд Тайван улсад суралцаж байсан их эмч Б.Алтангадас, сувилагч Б.Алтанчимэг нар сургуулиа амжилттай төгсөж ирсэн. - Америкийн нэгдсэн улсын virtue fandution сангийн 16 нүдний эмч нар ирж 2013 оны 05-р сарын 23-ны өдрөөс 2013 оны 05-р сарын 31-ний өдөр хүртэл ард иргэдэд үнэ төлбөргүй үзлэг оношилгоог давхардсан тоогоор 937 хүнд , нүдний мэс заслын хагалгааг 91 хүнд хийсэн - Япон улсын уруул тагнайн сэтэрхийн нийгэмлэгийн Ютака Имай ахлагчтай Япон Монголын эмч нарын баг 2013 оны 09-р сарын 23-ны өдрөөс 09-р сарын 26-ны өдөр хүртэл Бүсийн Оношлогоо, Эмчилгээний Төвд ирж Ховд аймгийн ард иргэдэд үнэ төлбөргүй үзлэг, оношилгоо хийж нийт 8 хүнд уруул тагнайн сэтэрхийн хагалгаа хийсэн. - Австрали улсын эмэгтэйчүүдийн дурангийн мэс заслын баг 5 хоног ирж ажилласан. • Франц улсын түлэнхийн арьс нөхөх мэс заслын эмч нарын баг 7 хоног ажилласан. • Швейцарийн хөгжлийн агентлагийн дэмжлэгээр тус улсаас эмч нарын баг, ЭХЭМҮТ-ийн эмч нарын багтай хамтран бүсийн аймгийн хэмжээнд нярайн түнхний ЭХО-ны ажлын байрны сургалтыг 2 өдрийн турш 2 багц багийн сургалт хийж түнхний үений ЭХО аппарат / 74,6 сая төгрөг/ хандивласан.
	<ul style="list-style-type: none"> • Нээлттэй зарласан сургалт, сонгон шалгаруулалтын тухай мэдээллийн тоо; 	<ul style="list-style-type: none"> - Байгууллагын хэмжээнд үндсэн мэргэшил эзэмших, төрөлжсөн мэргэшил эзэмших, мэргэжил дээшлүүлэх 37 сургалтыг нээлттэйгээр тасгийн эрхлэгч, эмч нар, сувилагч тусгай мэргэжилтнүүдийн хурлаар зарлаж, самбарт зарлал байрлуулан сонгон шалгаруулалт явуулж сургалтын гэрээ байгуулан дараах мэргэжилтэнг бэлтгэсэн. <p>Үүнээс их эмч Үндсэн мэргэшил эзэмших сургалтанд их эмч -15, төрөлжсөн мэргэшил эзэмших сургалтанд их эмч - 2,</p> <p>сувилагч тусгай мэргэжилтэн үндсэн мэргэшил эзэмших сургалт 14 сувилагч тусгай мэргэжилтэн төрөлжсөн мэргэшил эзэмших сургалтанд эм найруулагч-2, сувилагч-3,</p>

		техникч-1 тус тус хамрагдсан.
	<ul style="list-style-type: none"> Эмч, эмнэлгийн мэргэжилтний нийгмийн асуудлыг шийдэхэд үйлдвэрчний эвлэлийн байгууллагатай хамтран ажиллаж байгаа байдал, хамтын гэрээний биелэлтийн хувь. 	Байгууллагын үйлдвэрчний эвлэлийн хороотой хийсэн хамтын гэрээг 2013 оны 03 сарын 01-ний өдрөөс 2 жилийн хугацаатай 10 бүлэг 135 зүйлтэйгээр байгуулан Ховд аймгийн Жаргалант сумын тамгын газрын даргаар баталгаажуулан мөрдөн ажиллаж байна. Гэрээний биелэлтийг дүгнэхэд 97,1% байна.
<i>Гурав. Төсөв, санхүүгийн ил тод байдал</i>		
	<ul style="list-style-type: none"> Төсвийн гүйцэтгэлийн биелэлт болон хагас, бүтэн жилийн санхүүгийн тайланг байгууллагын цахим хуудас болон мэдээллийг самбарт байрлуулсан эсэх; 	<ul style="list-style-type: none"> - Төсвийн мэдээллийг сангийн яамны нээлттэй нийгмийн хүрээлэн www.khovdtusuv.wordpress.com цахим хуудсаар тогтмол мэдээлж ажилладаг - Төсвийн гүйцэтгэлийн мэдээг санхүүгийн албаны мэдээлэлийн самбарт сар бүр байршуулдаг
	<ul style="list-style-type: none"> Байгууллагын санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг бүрэн эхээр нь байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт байрлуулсан эсэх; 	<ul style="list-style-type: none"> - Байгууллагын санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг бүрэн эхээр нь байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт, ажилчдын хурал дээр тус тус танилцуулсан.
	<ul style="list-style-type: none"> Тухайн жилийн батлагдсан төсөвт нэмэлт, өөрчлөлт оруулсан тохиолдолд энэ тухай цахим хуудсаар болон бусад хэлбэрээр олон нийтэд мэдээлсэн эсэх; 	Төсвийн дутагдлыг тухай бүр гаргаж холбогдох газруудад танилцуулж мэдээлдэг
	Зөвхөн хууль тогтоомжид заасан төлбөр, хураамжийг үйлчлүүлэгчээс авах, үйлчилгээний хөлс болон төлбөр, хураамж авах хэлбэрийг боловсронгуй болгох чиглэлээр авсан арга	Төлбөр хураамжийг Эрүүл мэндийн сайдын 277 тоот тушаалын дагуу тарифыг ил тод байршуулж хэрэгжүүлдэг.

	хэмжээ,, үйлчлүүлэгчдийн төлөх төлбөрийн хэмжээ, тарифыг цахим хуудсаар болон олон нийтэд нээлттэй мэдээлсэн эсэх;	
	<ul style="list-style-type: none"> Албан бус төлбөрийн талаар арга хэмжээ авсан эсэх; 	Албан бус төлбөр байхгүй
	<ul style="list-style-type: none"> Гадаадын зээл, тусламж, хандивлагч олон улсын байгууллагуудаас авч хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрийн санхүүжилтын мэдээллийг цахим хуудсанд байрлуулсан эсэх. 	Швейцарь улсын хөрөнгө оруулалтаар 74,6 сая төгрөгний нярайн түнхний үеийн ЭХО аппарат, НҮБ-ийн хүн амын сангаас 54,0 сая төгрөгний эмэгтэйчүүдийн ЭХО аппарат, АНУ-ын нүдний эмч нарын тусламжаар 2 нүдний микроскопи тус тус бүртгэн байгууллагын данс бүртгэлд бүртгэсэн.
<i>Дөрөв. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдал</i>		
	<ul style="list-style-type: none"> Тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам болон тендерийн урилгыг хуульд заасны дагуу хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлж, цахим хуудас /www.e-procurement.mn/-т байршуулсан эсэх; 	2013 онд БОЭТ-ийн хэмжээнд нийт 5 төрлийн ажил үйлчилгээнд тендер шалгаруулалтыг зохих журмын дагуу урилгыг 14 компанид хүргүүлж шалгаруулалтыг аймгийн худалдан авах үйл ажиллагааны газартай хамтран зохион байгуулан ажилласан. Эм эмнэлгийн хэрэгсэлийг тендерийн хуулийн дагуу БОЭТ нийт 21 багцаар бэлдэн аймгийн Эрүүл мэндийн газраар дамжуулан Сангийн яамны цахим хуудсанд байршуулан зарлаж тендерт 10 компани шалгарч эм эмнэлгийн хэрэгслээр нийлүүлэн ажиллаж байна.
	<ul style="list-style-type: none"> Тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаархи товч мэдээллийг байгууллагын цахим хуудаст байршуулан, шалгарсан болон шалгарч чадаагүй шалтгаан, нөхцөл, хуулийн үндэслэлийн талаар мэдээлэл гаргасан эсэх; 	Орон нутгийн хөрөнгө оруулалтаар 63,9 сая төгрөгний тоног төхөөрөмж худалдан авах тендерт 3 компани оролцсоноос Үнэлгээний хорооны 2013 оны 12 сарын 11-ний өдрийн хурлаас үнэлгээний хорооны дүгнэлт, хурлын тэмдэглэлээс үндэслэн тендерийн гүйцэтгэгчээр шалгарсан “Мон орто мед” ХХК, “Ашид буян” ХХК-тай орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх БОЭТ-ийн тоног төхөөрөмж нийлүүлэх тендерийн гэрээг тус 2 байгууллагатай гэрээ байгуулан ажил үйлчилгээг гүйцэтгэсэн. - Цахим эмнэлэг хөтөлбөрийн хүрээнд орон нутгийн хөгжлийн сангийн / 30,2 сая төгрөг/

		<p>хөрөнгөөр Ховд оргил ХХК шалгарч тоног төхөөрөмжийг нийлүүлэн ажиллаа.</p> <ul style="list-style-type: none"> - ЭМЯ-ны хөрөнгө оруулалтаар хийгдсэн эмнэлгийн хог хаягдлын байрны засварын 19,0 сая төгрөгний тендер Биг Монголиа Билдинг ХХК шалгарч ажил үйлчилгээг хугацаанд нь хийж гүйцэтгэсэн.
	<ul style="list-style-type: none"> • Худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний тайланг тухай бүр холбогдох байгууллагад мэдээлсэн эсэх; 	<ul style="list-style-type: none"> - Худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний тайланг улирал бүр Эрүүл мэндийн газар, Ховд аймгийн засаг даргын тамгын газрын нийгмийн бодлогын хэлтэс, эрүүл мэндийн яаманд тус тус хүргүүлэн ажилласан.
	<ul style="list-style-type: none"> • Цахим хуудас болон мэдээллийн самбарт байрлуулсан худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт, шалгалтын дүнгийн талаарх мэдээллийн тоо. 	<ul style="list-style-type: none"> - Худалдан авах үйл ажиллагааны 2013 оны тайланд аудитын дүгнэлт хийлгүүлэн ажиллаж аймгийн мэргэжлийн хяналтын шалгалтыг 2013 оны 10 сард оруулсан.

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарын үзүүлэлт

ЭМЯ-ны харъяа төв эмнэлэг , БОЭТ, тусгай мэргэжлийн төв 2013 он

№	Шалгуур үзүүлэлт	2013 оны гүйцэтгэл	Тайлбар
2.1 Нийтлэг үзүүлэлт			
1	Орны фонд ашиглалт	107.5%	
2	Дундаж ор хоног	7,8	
3	Эмнэлэгт хоног болоогүй нас баралт\4-24 цагийн дотор\	9 буюу 20%	
4	Өр авлагын хэмжээ		
2.2 Өвөрмөц үзүүлэлт			
2.2.1 Төв эмнэлэг, БОЭТ			
5	Эрхтэн шилжүүлэн суулгасан байдал <ul style="list-style-type: none"> • Эрхтэн шилжүүлэн суулгасан тохиолдлын тоо • 1 жилээс дээш амьдарч буй хүний хувь • 3 жилээс дээш амьдарч буй хүний хувь • 5 жилээс дээш амьдарч буй хүний хувь 		Эрхтэн шилжүүлэн суулгах хагалгаа хийгддэггүй
6	Гемодиализ эмчилгээний хүлээгдлийн дундаж хугацаа		
7	Ходоодны шархлаа өвчний шалтгаант нас баралтын түвшин (0-74 насны 10000 хүн амд)	0	
8	Даралт ихсэх өвчний шалтгаант нас баралтын түвшин (0-74 насны 10000 хүн амд)	0	
9	Гуурсан хоолойн багтраа өвчний шалтгаант нас баралтын түвшин (0-74 насны 10000 хүн амд)	0	
10	Мухар олгойн шалтгаант нас баралтын түвшин (0-74 насны 10000 хүн амд)	0	
11	Цөсний чулуу, цөсний үрэвсэлийн шалтгаант нас баралтын түвшин (0-74 насны 10000 хүн амд)	0	
12	Тархинд цус харвалтын нас баралтын түвшин (0-74 насны 10000 хүн амд)	1,14	
13	Зүрхний шигдээсийн нас баралтын түвшин (0-74 насны 10000 хүн амд)	0	
14	Тухайн эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэний дараа эсвэл шилжүүлсний дараа нэг сарын дотор нас барсан тохиолдлын хувь (нийт хэвтэн эмчлүүлэгчдийн дотор)		Статистик мэдээлэлийн программд суугдаагүй юм байна/ Бүртгэгддэггүй/

